



I–XII/2021

Тархаасан: 2022 оны 01 дүгээр сарын 14



Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан хүний тоо өмнөх оноос 93 мянга (3.6%)-аар буурлаа


Нийгмийн Даатгалын Ерөнхий Газрын мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2021 онд 3423.7 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 735.4 (27.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оноос өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн орлого 581.8 (28.5%) тэрбум төгрөгөөр, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 64.1 (50.2%) тэрбум төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 67.2 (19.8%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

ЗУРАГ 1. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, тэрбум төгрөгөөр, сараар



Нийгмийн даатгалын сангийн зарлага 2021 онд 3245.3 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 35.3 (1.1%) тэрбум төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 125.5 (5.8%) тэрбум төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 85.9 (26.7%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв. Харин үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн зарлага өмнөх оноос 163.9 (34.9%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

ЗУРАГ 2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ АВАГЧИД, төрлөөр, жил бүрийн эцсийн байдлаар



Тэтгэврийн даатгалын сангаас 2021 онд 460.6 мянган хүнд 2304.5 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оноос 11.4 (2.5%) мянган хүнээр нэмэгдэж, олгосон тэтгэврийн хэмжээ 125.9(5.8%) тэрбум төгрөгөөр өсжээ.

Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжид 2021 онд 180.4 мянган хүнд 34.0 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оноос 65.4 (56.8%) мянган хүнээр нэмэгдэж, олгосон тэтгэмжийн хэмжээ 10.8 (46.3%) тэрбум төгрөгөөр өсөхөд Коронавирусийн халдварын улмаас өвчилсөн даатгуулагчийн тоо нэмэгдсэнтэй холбоотой.

Нийгмийн халамжийн сангаас 2021 онд давхардсан тоогоор 2.5 сая хүнд 1971.8 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлт олгосон нь өмнөх оноос нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид 93.0 (3.6%) мянгаар буурсан хэдий ч олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлтийн хэмжээ 389.9 (24.6%) тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

Нийгмийн халамжийн сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ нэмэгдэхэд Монгол Улсын Засгийн газраас иргэдийн амьжиргааг дэмжих чиглэлээр нийгмийн халамжийн сангаас олгож буй халамжийн тэтгэвэр болон байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн хэмжээг 2020 оны 4 дүгээр сараас 2022 оны 1 дүгээр сарыг хүртэл 288.0 мянган төгрөг, хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хэмжээг 2020 оны 4 дүгээр сараас 2022 оны 7 дугаар сар хүртэл 100.0 мянган төгрөг болгосон нь нөлөөлжээ.

Өмнөх онтой харьцуулахад Хүүхдийн мөнгөн тэтгэмж авсан 0-18 хүртэлх насны хүүхдийн тоо 33.8 (2.8%) мянгаар, олгосон тэтгэмжийн хэмжээ 402.2 тэрбум (38.2%) төгрөгөөр нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 1. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАГЧИД, төрлөөр, жил бүрийн эцсийн байдлаар

Үзүүлэлт	2018	2019	2020	2021	<u>2021</u> <u>2020</u>
	хүн				хувь
Бүгд	1 900 211	2 359 383	2 553 972	2 460 948	96.4
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээ	378 899	431 543	429 821	373 350	86.9
Тэтгэвэр	59 670	60 658	59 110	74 583	126.2
Тэтгэмж	60 756	120 132	121 728	123 886	101.8
Үйлчилгээ (халамжийн, хөгжлийн)	258 473	250 753	248 983	174 881	70.2
Эхийн алдар одонгийн мөнгөн урамшуулал	219 386	224 130	230 189	239 189	103.9
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	950 000	1 000 000	1 186 289	1 220 079	102.8
Ахмад настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлт	104 469	194 565	236 718	135 895	57.4
Алдар цолтон ахмад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт	5 296	2 755	2 518	2 405	95.5
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	11 610	57 924	38 420	33 095	86.1
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	97 828	312 556	287 855	298 925	103.8
Насны хишиг	132 723	135 542	141 765	157 615	111.2
Цаатан иргэний тэтгэмж	-	368	397	395	99.5

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2021 онд 74.6 мянган хүн хамрагдсан нь өмнөх оноос 15.5 (26.2%) мянган хүнээр, олгосон тэтгэврийн хэмжээ 184.4 тэрбум төгрөг болж 21.6 (13.3%) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийгмийн халамжийн тэтгэвэрт хамрагдсан иргэдийн 71.8 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 21.9 хувь нь тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд, 6.2 хувь нь ахмад настан, 0.1 хувь нь 16 насанд хүрсэн одой иргэн байна.

Нийгмийн халамжийн тэтгэмжид 2021 онд 123.9 мянган хүн хамрагдсаны 52.4 хувь нь асаргааны тэтгэмжид, 47.6 хувь нь онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид хамрагдсан иргэд байна. Нийгмийн халамжийн тэтгэмжид 2021 онд 103.0 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 4.0 (4.0%) тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 2021 онд 167.3 мянган хүн хамрагдсан нь өмнөх оноос 69.1(30.9%) мянган хүнээр буурсан нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдах өрхийг тодорхойлох журмаа өөрчилсөнтэй холбоотой.

18 хүртэлх насны 1.2 сая хүүхдэд 1455.2 тэрбум төгрөгийн хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 2021 онд олгожээ.

Ойлголт, тодорхойлолт

Нийгмийн даатгал

Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан

Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч

Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр

Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Тэтгэмж

Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль

заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна.

Эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг **нийгмийн халамж** гэнэ.



Эх үүсвэр:

Нийгмийн даатгалын ерөнхий газар,
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>
<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ гархаах хуваарь:

2022 оны 4 дүгээр сарын 13

Нийгмийн статистикийн
газрын дарга А.Амарбал
Утас : (976-51)-264805

Нийгмийн статистикийн газрын
статистикч Э.Ариунчимэг
Утас : (976-51)-263966



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212